

**"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН"-Ы "buqa'u" ХЭМЭЭХ ҮГИЙН
ОЙР ТОЙРОНД ШИНЖЛЭХ НЬ**

Ш.Чоймаа *

"Мисир (Египет) хэмээх эртний улсын хөшөө дурсгалын зүйлд хоёр гараа ардаа холбуулан хүлүүлж боолгосон олон боол, олзны зовлонтны дүрс нүдэнд, эл боол гэдэг монгол үгийн гарлыг бодоход үзэгдэх мэт агаад, хүн төрөлхтний өнгөрсөн түүхийг нэхэн бодоход маш гашуун дурсгал төрүүлэх үг ажаам."

Академич **Б.Ринчен**
"Монгол бичгийн хэлний зүй", (Авиан зүй), 1966.

"Монголын Нууц Товчоо" бол агуулга, хэмжээ, үгийн сангийн баялаг гэх мэт олон талаараа дундад үеийн монгол хэлний нэн чухал сурвалж бичиг юм. Гадаад, дотоодын үе үеийн эрдэмтэн судлаачид МНТ-г тал талаас нь судалж, өдий төдий бүтээл гарсан хэдий ч судлах эзнээ хүлээсэн зүйл ч мөн арвин байсаар...

Би санаваас, МНТ-ны үг, холбоо үг бүрийн тухайн үеийн үгийн сангийн утга орчин цагийн монгол хэл хүртэл хэрхэн улирч хувьсч, уламжилж хадгалагдаж ирэв гэдгийг судлан шинжлэх нь эрхэм чухаг хэмээн бодож, савны хирээр нухаж сууна.

Энэ өгүүлэлд МНТ-ны "buqa'u" хэмээх үгийн тухай бичих бөгөөд уг үг МНТ-нд 5 удаа тохиолдох ажээ. Тэдгээр нь:

&81: ...qurim-un haran-i tarqa'ulun tere gelbyri kц'ьn-eče buqa'u tataju abcu, heki inu niken-te deledь'et гьуйь... usun-u qarki-tur gedergy kebteжь buqa'u-ban usun huru'u urusqan ni'ur ile kebteba (1:31)

& 83: ... qa'a otqu tere buqa'utu гь'ьn ke'eba (1:32)

& 84: ... buqa'u minu a[b]cu sulala...u qono'a'ululai (1:33)

& 85: ... buqa'u inu cucal...u qal-tur тьe...ь (1:33)

&112: ... qa'atai-darmalay-yi ... abciraju qa[b]tasun buqa'u емьсгежь qaldun-burqan-na jori'ulba (1:46).

МНТ-ноос дээр эшлэсэн хэсэгт **"buqa'u tataju abcu"** (бугуу(гаа) татаж авч), **"buqa'u-ban usun huru'u urusqan"** (бугуугаа усан руу урсган), "buqa'utu гь'ьn" (бугуут хүн), (buqa'u minu a[b]cu sulala...u (миний бугуу [г] авч суллаж), "buqa'u inu cucalju" (түүний бугуу [г] цуцалж), **"qa[b]tasun buqa'u емьсгежь"** (хавтсан бугуу өмсгөж) хэмээн гарч байгааг судлаачид орчин цагийн монгол хэлэнд хэрхэн хөрвүүлж, харь хэлэнд хэрхэн орчуулсныг ажиглая.

Богд хаант Монгол улсын үед Гадаад яамны дэд сайдын алба хашиж байсан Баргын Цэнд гүн 1917 онд Нийслэл хүрээнээ, МНТ-г хятад галиг эхээс нь (Е-Де-хуйн модон барыг баримтлан Ш.Ч) монгол хэлэнд анх удаа хөрвүүлсэн ажээ. Бидний үед

* МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг судлалын тэнхим

уламжилж ирсэн МНТ бол 14-р зууны сүүл үес, уйгуржин монгол бичгээр туурвисан эртний түүхэн товчооныг монгол дуудлагаар нь хятад үсгийн тэмдгээр галиглаж, үг бүрийн хажууд хятад орчуулга хадаж, бас зүйл хэсэг бүрийн хойно утгачилсан товч хятад орчуулга дагалдуулсан эх гэдгийг судлаачид бэлхнээ мэдэх билээ.

Цэнд гүн МНТ-ны эхийг монгол хэлнээ хөрвүүлсэн төдийгүй бас зүйл хэсэг бүрийн хойнох утгачилсан товч орчуулгыг мөн монголоор орчуулсан байна. Үүнд, тэмдэглэх зохистой нэгэн зүйл болбоос, Цэнд гүн хятад галиг эхийг тэр үеийн хэллэгээр нь хөрвүүлж, харин товч хятад орчуулгыг орчин цагийн монгол хэлэнд ойр дөт болгон найруулж орчуулжээ. Үүнийг энд тухайлан шинжилж буй "buqa'u" хэмээх үгээр жишээлж болно. МНТ-ны 81-р зүйлийн "... buqa'u tataju abcu, heki inu niken-te deledy'et..." хэмээснийг Цэнд гүн "buqayu tataju abcu, heki ine nigen-te deleddyged ..." (2:129) гэж эхийг баримтлан хөрвүүлсэн бол уг хэсгийн товч хятад орчуулгыг монголчлохдоо "terekь цькен кцбегьн-ь toluяai-yi modu-bar cokin unayayad" (2:130) гэж орчуулжээ. Энд дундад үеийн монгол хэлний "buqa'u" (бугуу)-г "мод", "heki" (эхэн)-ийг "толгой", "deledkь" гэдгийг цохих хэмээн өдгөөчилж орчуулжээ. Сая дурдсанаас цаана, МНТ-нд "buqa'u" гэдэг үг 4 удаа гарч байгаа бөгөөд түүнийг Цэнд гүн эх товчооны хөрвүүлэгтээ "buqa'u" гээд, товч орчуулгыг нь монголчлохдоо "dцngge" (дөнгө) гэдэг үгээр өнөөгийн хүмүүст ойлгомжтой болгон орчуулжээ.

Цэнд гүнгийн МНТ-ны хөрвүүлгийн тухай цухас дурдсанаас улбаалан өгүүлэхэд, "Энэ бүтээл нь МНТ-ыг сонгодог бичгийн хэлээр буулгах гэсэн анхны оролдлого байсан учир хятад галиг үсгийн нэмэлт тэмдгийн үүргийг бүрэн ухаагүй зэргээс газар орон, хүний нэр тэргүүтнийг хааяа заримдаа хазгай тэмдэглэсэн зэрэг мадаг сэжиг байвч "Монголын нууц товчоо"-г өнөөгийн уншигч, судлагчид зөвөөр ухаж, ухаарахад чухал үүрэг гүйцэтгэсэн гавьяатай" (3:23) бөгөөд ялангуяа түүний МНТ-ны эхийн хөрвүүлгийг, утгачилсан товч хятад орчуулгыг монголчилсонтой нь харьцуулан үзэх нь чухал ажил болохыг тэмдэглэе.

МНТ-ны "buqa'u" гэдэг үгийг академич Ц.Дамдинсүрэн дөнгө (4:50, 51, 68), Тайчуудай Мансан мөн дөнгө (5:51, 53), академич Д.Цэрэнсодном дөнгө (3:48, 49), гав (3:49) гэж хөрвүүлсэн бол профессор Баяр "baуu" (6:168, 178, 182, 318), профессор Ихмянгадай Иринчин "buqayu" (7:52, 53, 54, 55, 79), эрдэмтэн Ш.Гаадамба "baуu" (8:33, 34, 112), Элдэндэй Ардаажав нар "buqayu" (9:181, 182, 189, 190, 283) гэж эх галигийг баримтлан буулгажээ. Тайчуудай Мансан, Ихмянгадай Иринчин, Ш.Гаадамба, Элдэндэй, Ардаажав нар уг үгийн тухай товч зүүлт тайлбар хийжээ.

МНТ-г харь хэлээр орчуулсан нэрт эрдэмтдийн орчуулгыг нягталбаас, П.Пеллио францаар "entraves" (10:137), Е.Хэниш германаар "baha'u-Schandkragen; hatasun buha'u-Holzbrettkragen" (11:21), Ф.В.Кливез англиар "buqa'u - wooden collar, a cangue" (12:277), Онон Өргөнгөө англиар "wooden halter" (13:18), С.А.Козин оросоор "колодка, шейная колодка" (14:27, 28), Ахмет Темир туркээр "bukagi" (15:31, 32, 50), С.Калужинский польшоор "dyby" (16:233) хэмээн тус тус орчуулж, Ф.В.Кливез, Ахмет Темир, С.Калужинский нар тухайн үгийн орчуулгадаа зүүлт тайлбар хийсэн байна.

Дээр дурдсан эрдэмтэд МНТ-ны "buqa'u" гэдэг үгийг орчуулахдаа хажуугийн хадмал хятад орчуулга болон хам сэдэвт нь шүтэж, "дөнгө, модон хүзүүвч, гав гинж" гэсэн утгатай тус тусын хэлний үгээр орчуулсан байх бөгөөд Алтай хэлний нэгэн болох түрэгээр "bukagi" гэж хэлдэг нь сонирхол татаж байна.

Японы нэрт монголч эрдэмтэн, профессор Ш.Озава "МНТ-ны бүрэн тайлбар" хэмээх 6 боть зохиол туурвисан бөгөөд тэрбээр "buqa'u" гэдэг үгийг дөнгө гав гэсэн утгатай үгээр орчуулж, зүүлт тайлбартаа В.В.Радловын "Түрэг хэл, аялгуунуудын толь бичиг"-т "быгау" (175113, 114) гэж байгааг эшлэж, уйгуржин бичгийн сэргээлтдээ "buqayu" (17-454) гэж буулгажээ. Элдэндэй, Ардаажав нар профессор Ш.Озавагийн адил В.В.Радловын толийг зааж, "быгау" гэсэн түрэг үг гэж үзжээ.

МНТ-ны хятад эх галигийн хажуугийн хадмал орчуулгад "buqa'u" гэдэг үгийг "枷jiā" гэж орчуулсан бөгөөд энэ нь дөнгө, гав гинж (185725) гэсэн утгатай ажээ. Харин орчин цагийн хятад хэлэнд гав дөнгийг "铐 kao" гэж хэлж, бичдэг бөгөөд сонирхолтой нь 枷jiā гэсэн ханзны түлхүүр үсэг нь мод гэсэн утгатай бол као гэсэн ханзны түлхүүр үсэг нь төмөр гэсэн утгатай ажээ. Энэ нь эртний Хятадад ялтныг гэсгээн цээрлүүлэхдээ модон бугуу буюу модон дөнгө хэрэглэж байгаад, хожим төмөр гав гинж хэрэглэх болсныг гэрчлэх баримт буй за.

МНТ-г судалсан эрдэмтдийн дийлэнх нь үгийн хэлбэр, утга нь бэлхэн ойр байгаагаар нь түрэг үг гээд заачихаж байна. Гэтэл "buqa'u" гэдэг уг үг Алтай язгуурын хэлний үг бөгөөд олон монгол хэл, аялгуунуудад хэлбэр, утга нь их багаар улиран хувьссаар хадгалагдаж байна. Түрэг төрлийн олон хэлнүүдэд ч байдал мөн адил ажээ. Барууны хойт Хятадын нутгаас С.Е.Малов 1910 онд олсон уйгур бичгээр буй "Алтан гэрэл" (Altan jaruq) буюу Suvarnaprahāsa сударт "buγayu luγ" (20:150, 156) хэмээн бичсэн бөгөөд "дөнгө бүхий, дөнгөлөгдсөн" (20:159) хэмээсэн утгатай ажээ. Эртний түрэг хэлний дурсгал болох Махмуд Кашгарын толь (1072-1074) болон Турфанаас олдсон дурсгалд "boγayu, boqayu, buqayu" (19:109, 125) гэсэн хэлбэртэй тохиолдох бөгөөд ялтанд өмсгөх дөнгө, гав гинж гэсэн утгатай байна. Түүнчлэн дөнгө гавыг зүүж, ялтныг цээрлүүлэгч хүнийг "buqayuči, boqayuči" (19:112, 125) гэдэг байжээ.

Түрэг төрлийн хэлнүүдэд тухайлбал, цагаадай хэлэнд "bokak, boγau, boγayu, bukaγu" (хөлийн тушаа) (21:87); киргиз хэлэнд "богоо" (22:271); каракалпак хэлэнд "бугау" (23:326); орчин цагийн турк хэлэнд "bukagi" (24:88); казак хэлэнд "бугау", "бугаулык" (25:191) гэх мэт хэлбэрээр тохиолдох бөгөөд үндсэн утга нь гав гинж, дөнгө ажээ. Түрэг төрлийн зарим хэлэнд ялтанд өмсгөх дөнгө гэсэн үндсэн утга нь шилжирсэн байдал бас ажиглагдаж байна.

Алтайн язгуурын хэлтнүүд ялтанд модон бугуу (buqayu) өмсгөж, дээс сур мэтсээр хүлж баглахын оронд, бат бэх төмөр гав гинж зүүх болсон үеэс "бугуу" гэдэг үгийн анхны үндсэн утга хуучран шилжиж, харин түүний оронд "гинж" (ginji) гэдэг үгийн олон хувилбар хэрэглэгдэх болжээ. Жишээлбээс, тува хэлэнд "кинчи" (26:349), каракалпак хэлэнд "шынжыр" (23:570), таджик хэлэнд "занчир" (27:621), орчин цагийн уйгур хэлэнд "зэнжир" (28:474) (Эртний уйгур хэлэнд "buγayu" гэж хэлж бичиж байсныг өмнө дурдсан. Ш.Ч), халх аялгуунд "гав гинж", буриад хэлэнд "түмэр гэнжэ", "гэнжэ шүдэр" (29:358), халимаг хэлэнд "төмр чөдр" (30:227) гэх мэтээр хэлэх болжээ. Инжаннашийн "Хөх судар"-т гавыг гавж (γabji) гэж бичсэн байдгийг тэмдэглэе.

Дээр өгүүлснийг монголын түүхийн сурвалж бичгүүд давхар нуталж байна. МНТ дахь "...qurim-un haran-i tarqa'ulun tere gelbγi kц'н-еёе buqa'u tataju abcu, heki inu niken-te deledь'et гьуйь..." гэсэн хэсгийг Лувсанданзаны "Алтан товч"-д "...qurim-un haran-i tarqayuluγad tere kilbar-a keьked кьмьн-i ginji baγu-bar-iyen ekin-i inu deledьged гьуйь..." (31:14) гэж буй. 17-р зууны түүхч Лувсанданзан эртний уйгуржин монгол бичгээр бичсэн сурвалжийг ашиглах үедээ "bukayu" гэдэг үгийн утга хуучирсныг ухаж, "гинж" гэдэг үгээр тодотгон бичсэн нь илт байна. "Хураангуй алтан товч"-ийн өнөө хир олдоод байгаа эхүүдийг шүүн үзэхэд, Тэмүжинийг тайчууд барьж аваачсан тухай өгүүлэхдээ "темьjin-i bariγad gertyr-iyen abačiju, ginji baγu bayulaγu nigen kilbar кьмьн-iyer qadaγalayulju talbiba. Темьjin tere кьмьн-i ginji-ber čokiju orkiγsan-tur tere кьмьн bosuγad barkiran dayudaba" (32:24) гэж бичсэн буй. Зарим эхэд нь "гинж" гэсэн тодотгосон холбоо үгийг хэрэглээгүй газар байгааг ажиглах ёстой. Саган сэцэний "Эрдэнийн товч"-д өгүүлэн буй хэрэг явдлыг тэмдэглэхдээ "... tedьu-e barin abcu oduγad, темь ginji темь tusiy-a емьsgen, ger bьri-de ulariγu qadaγalan abai. tende jun-u dumdadu sar-a-yin arban tabun-a, tayičiyud yeke qurim kiγ arkidan бькьу-e sцni bolqui-dur kцl-iyen tusiyan-i quγu musgin, tere sakiγči кьмьн-

i ginji-ber čokiju orkiyad dutayaju odbai" (33:135) гэжээ. Түүхч Саган сэцэн "buka'u" гэсэн хуучин үгийг хэрэглээгүйгээр үл барам "төмөр гинж, төмөр тушаа" хэмээн улам тодотгон, тухайн үеийн нэрийдлээр бичсэн ажээ.

"Эрдэнийн товч"-д төмөр тушаа гэж гарснаас үүдэн өгүүлэхэд, төв Азийн нүүдэлчид эрт цагт олзолсон гэмтэн зэмтний хүзүү, гарт нь "бугуу бугуулж" моринд мордуулан давхин оддог байсан биз. Харин хөлд нь төмөр тушаа зүүх болсон нь тун хожмын хэрэг явдал болов уу гэж санана.

Алтай язгуурын хэлний боох (boɣuqu), баглах (baɣlaqu) гэсэн утгатай үйл үгээс үүсэл ирэлтэй "бугуу" (buɣaɣu) гэдэг үг угийн нэрлэж байсан утгаа алдаж, хуучрахын хамт утга нь шилжирч хүний хүзүү, гарын бугуй зэрэгт зүүх гоёл чимгийг нэрлэх болжээ.

Монгол хэлний анхны тайлбар толь болох "Хорин нэгт тайлбар толь" (1717 онд барласан)-д "Алтан мөнгөний зэргийн юмыг эсвээс моголцог, эсвээс хавтгай болгон товин* үйлдэж, хойтод товчуурлан чимсэн, санжлага уяж, эхнэрүүд хүзүүнд зүүхийг нь бугуу (baɣu) хэмээмүй" (34:228) гэж тайлбарлажээ. Үүнээс нэхэн бодвоос, хүний хүзүүнд зүүх гоёл чимгийг "хүзүүний зүүлт" гэж тайлбар үгээр нуршуулан нэрлэх болсон нь тун саяхны хэрэг ажээ.

Энгийн ард иргэний гоёл чимэг зүүдэг газар нь гарын бугуй, хуруу л байсан гэж хэлж болох биз. Тийм ч учраас тэдгээрийг нэрлэх үгс олон монгол хэл, аялгуунуудад олон хувилбараар тохиолдох юм. Тухайлбал, гарын бугуйнд зүүх гоёлыг халх аялгуунд "бугуйвч"; буриадын аялгуунуудад "бугааг, бугаавша, бугабши, бугуйвчи"; өвөр монголын олон аялгуунуудад, тухайлбал, хорчин, дөрвөд, ар хорчин, баарин, огниуд, сөнид, найман, хишигтэн, харчин, түмэд, цахар, ордост "бугуу"; горлос, жалайдад "бугаа"; авга, дархан-мянганд "бугуувчи" (35:91) (44:126); үзэмчний салбар аман аялгуунд "боого" (35:91); хамниган аялгуунд "бугаа"; дагуур хэлэнд "bagiэ"; зүүн ёгур хэлэнд "boɣobči"; монгол хэлэнд "baɣaur" гэх мэтээр хэлдэг байна.

Ялтан гэмтний хүзүү, бугуйнд өмсгөж байсан "бугуу" хэмээх гэсгээн цээрлүүлэх хэрэгслийн нэр нь улмаар гоёл чимгийн нэр болсноор зогссонгүй, бас дахин утга шилжиж, төв халхын аялгуу зэрэгт уг гоёл чимгийг зүүдэг "хүний богт чөмөгний нарийн үзүүрийн тус газар" (36:102)-ыг нэрлэж, харин түүнд зүүх гоёлыг бугуйвч гэж нэрлэх болжээ. Гэвч өдгөө Монголын олон ястны аялгуу, тухайлбал, дөрвөд, захчин, торгууд, өөлд, урианхай, баяд, хотон зэрэг ойрд аялгуунд гарын бугуйг ч, гарын бугуйнд зүүх гоёл чимгийг ч адилхан "бугуу" (37:123) хэмээн нэрлэж байна.

МНТ-нд 5 удаа тохиолдох "buka'u" (бугуу) гэдэг үгийн тухайн үед заан нэрлэж байсан үгийн сангийн утга одоогийн төв халхын аялгуу хүртэл хэрхэн улирч хувьсч ирснийг товчлон өгүүлэхэд ийм бөгөөд "buka'u" (buɣaɣu) гэдэг үгийн язгуур бүтээвэр, түүний хувилбарууд аванзүйн ямар хувьслыг үзэж, ямар үгсийн язгуурт хадгалагдан явааг бас дурдах ёстой.

МНТ-ны "buka'u" хэмээх үгийн эртний хэлбэр нь В.Радловын тольдоо тэмдэглэсэнчлэн "biɣaɣu" байгаад тэргүүн үеийн эр эгшиг "i" нь дараахи үеийнхээ эгшигтэй ухран ижилшиж, ба-, бо-, бу- буюу ba(ɣ/k)-, bo(ɣ/k)-, bu(ɣ/k)- гэсэн хувилбарууд буй болжээ. Мөн be(g/k)-, бц(g/k)-, бь(g/k)- гэсэн хувилбартай ч болсон мэт. Тэрхүү язгуур бүтээврүүдийн хувилбарыг тээн хадгалж яваа үгсээс авч үзье.

Эртний түрэг хэлэнд:

boɣ - душить (багалзуурдан алах), сдавливать (шахах, базах)
(19:109)

buq - сгибать подгибать (нугалах, матах) (19:125)

* **Тових** - төмөрлөг буюу бусад юмны дээр товойтол хээ угалз гаргах (43:179).

baγ - оковы, узы (гинж, хүлээс) (19:77)
 baγla - привязывать (уях) (19:77)
 boγaz - горло, глотка (хоолой багалзуур) (19:109)
 boγla - связывать в узел (зангидах) (19:109)
 boγum-boγim - узел, сустав, сочленение (зангилаа, үе гишүү) (19:109)
 boγuq - опухаль парыв на горле, зоб (хавдар, хоолойн буглаа, бахлуур) (19:109)
 bek - замок, запор (цоож, түгжээ, оньс) (19:92)
 bekId - запирасть (түгжих) (19:92)
 бцк - запруживать (хаах, хаалт хийх), перекрывать (дарах, бөглөх) (19:117)
 бцкдп - преграждаться (хаагдах, боогдох), закрываться (хучигдах, хаагдах) (19:117)

Монгол бичгийн хэлэнд:

baγalaqu (баалах) - идээлэн буглах
 baγaljur (багалзуур) - төвөнгийн орчин газар
 baγla (багла-) - боож хүлэх
 baγuu (бугуй)
 baγubči (бугуйвч)
 baquu (бахуу) - хүн амьтны багалзуур болон хоолойн өвчин
 baγalцаγ (багалцаг) - шуу ясны алгатай залгалдаж байгаа хэсэг
 baki (бахь) - төмрийг зуулган таслах багаж
 boγus (боос) - хээл бүхий
 boγuči (богоч) - морь малын урд хөлийг бохируулан торгох сур дээс
 boγučila (богочло-)
 boγumi¹ (боомь) - морь малын хүзүүнд углан цалмадах дээс
 boγum-a (боом) - монгол гутлын зулаг түрийн хоёрын уулзар
 boγum (боом) - хавцал боомт
 boγu (боо-) - уях, хүлэх
 boγul (боол) - Монгол хэлний эртний дурсгал бичигт boγul бус
 boγal гэж байдгийг санах ёстой.

 boγtu² (богт) - амьтны шилбэ, бугалаг (агтаал) хоёрын
 хоорондох чөмөг яс.
 buγuyili (бугуйл) - адуу мал барихад хэрэглэх үзүүртээ гогцоотой
 урт боомь
 buγulaγ-a (буулга) - хөлөх малын хүзүүн дээгүүр тавьж уях
 бөгтөр зүтгүүр мод
 buγla (бугла-) - арьсны дотор битүү идээлэх
 бцgle (бөглө-) - хаах, таглах
 бцgeji (бөгж) - юманд чимэг болгох буюу бэхлэхээр хийсэн зүйл
 (36:96)

 beki (бэх)
 bekile (бэхлэ-)

¹) Дээд монголын аман аялгуунд үхрийн хүзүүвчийг "bomo" гэдэг. (42:415).

²) Мөн бас boγtus, boγtuγusu гэдэг байна. Хүний шууны ясны өөр нэрийдэл гэж Сэцэнцогт "Монгол үгсийн язгуурын толь"-доо тэмдэглэжээ. Хүн, малын урд мөч буюу барьж авдаг, баглаж боодог чөмөг ясыг нь тийн нэрлэсэн болов уу.

bцke (бөх)
bцkele (бөхлө-)

Алтай хэлний авианзүйн ижил ондоошил, сэлгэх ёс хийгээд үгийн утга улиран шилжих зүй тогтлыг анхааран үзвэл, МНТ-ны "buka'u" гэдэг үг нь жишээ болгосон эртний түрэг хэлний boγ-(багалзуурдан шахах), buq- (нугалах, матах), bay- (гинж хүлээс); монгол хэлний boγu-(боох), boγuči (богоч), boγumi (боомь), bayla- (баглах), bayuu (бугуй) зэрэг үгстэй язгуур нэг болох нь тодорхой буй. Мөн тухайн үгийн утга улам холдож, боож боомилсноос шалтгаалан хавдаж бугласан дүр байдал, түүнтэй төс бүхийг ч нэрлэх болжээ.

Манж түнгүүс хэлний материалыг шүүн үзэхэд баримт бас олдох ажээ. Э.В.Севортяний тэмдэглэснээр эвенк хэлэнд "бок" (уях, барих, зогсоох), нанай, ульч хэлэнд "боки" (холбох) (45:30) гэсэн үгс тохиолдох бөгөөд манж бичгийн хэлэнд "bugdembī" (нугалмуй), "bugderi" (эвхмэл), bohiqu (ороодос), bohimbī (ороодосломуй), beki (бэх), bekilembī (бэхэлмүй), bagsalaha (баглав, багласан) (38:213, 220, 235, 240, 241) гэх мэтээр тохиолдож байгааг өмнө жагсаасан үгстэй холбон үзэж болох буй за.

Гэмтэн зэмтний хүзүү хоолой, бугуй сарвуунд өмсгөж байсан "бугуу" (buγayu) хэмээх гэсгээн цээрлүүлэх хэрэгслийн нэр нь улмаар утга шилжирч, гоёл чимгийн нэр болсноор барахгүй, төв халхын аялгуу зэрэгт бугуйвч зүүдэг хүний богт чөмөгний нарийн үзүүрийн тус газрыг нэрлэх болжээ гэсэн дүгнэлтийг өмнө өгүүлсэн билээ.

Тэгвэл эрт цагт хүний богт чөмөгний нарийн үзүүрийн тус газар буюу бугуй (bayuu) –г юу гэж нэрлэж байсан бэ? гэдэг асуулт зүй ёсоор урган гарна. Нэрт монголч эрдэмтэн Н.Поппе "Алтай хэлнүүдийн харьцуулсан хэлзүй" (1960)-дээ "Монгол хэлэнд bile "Handgelenk" (гарын бугуй), bileceg "Ring Armband" (бөгж, цагираг, бугуйвч), эвенк хэлэнд bilēn "Handgelenk" (гарын бугуй), ламут хэлэнд bilēpen "Armband" (гарын бугуй), Азарбайжанд bildk "Handgelenk" (гарын бугуй), Якут хэлэнд bild "Umschlag an Kleidungsstück" (нударга)" (39:117) гэж хэлдгийг тэмдэглэсэн нь өмнө тавьсан асуултын хариулт хэмээн хэлж болно. Судлаач В.Д.Колесниковагийн "Алтай язгуурын хэлнүүд дэх хүний бие эрхтний нэрийдэл" (1972) гэсэн судалгааны өгүүллээс үзэхэд, эртний түрэг хэлэнд "bildk" гэдэг нь гарын бугуй бөгөөд шилжсэн утга нь нударга аж. Турк, туркмен, тува, азарбайжан, башкир, татаар, казак, киргиз, кумык, ногай, узбек, уйгур зэрэг хэлэнд авианзүйн ялимгүй өөрчлөлттэй тохиолдох боловч утга нь цөм гарын бугуй, гарын сарвууг нэрлэдэг байна (40:97). Якут хэлэнд "bild-bild" гэдэг нь ханцуйн нударга, гутлын эргэмэл түрийг хэлэх ажээ (40:97). Түнгүүс хэл болох үдэгэй хэлэнд "билэ" гэдэг нь мөн якут хэлтэй адил нударга, гутлын эргэмэл түрий, хажлага эмжээрийг нэрлэдэг байна (40:97). Алтай язгуурын хэлтэнд bile гэсэн язгуур бүтээвэр бүхий үгс нь хүний гарын бугуй орчмыг нэрлэх төдийгүй цагираг гархин чимэг зүүлт, бүс ороодос зүүж хэрэглэж болох бие эрхтний тэр нарийлаг газрыг нэрлэсэн байх нь түгээмэл юм. Харин монгол хэлний тухайд зарим зүйлийг тодруулахад, орчин цагийн монгол хэлний төв халхын аялгуунд "бэлзэг", "бэл", "бэлхүүс", "бэлхнэг, бэлхэнцэг", "бэлхэмж" (1. Хүний бэлхэнцгээр өмсөх хувцас; 2. Морины эмээл ба тохмын гадуур даран торгох тусгай олом (36:122) гэх мэт үгсийн язгуур бүтээвэр нь алтай язгуурын хэлний "билэ (bile)"-тэй гарал үүсэл нэг ажээ.

Орчин цагийн монгол хэлний төв халхын аялгуунд хуруунд зүүх цагираг гоёлыг ярианы хэлэнд бөгж, бичгийн хэлэнд бэлзэг (олон хувилбартай) гэдэг. Бэлзэг гэдэг үг нь бэл (bile)-д зүүдэг цагираг гэсэн утгатай болох нь эртний түрэг хэлний баримтаар нутлагдаж байна. Бүтэц нь "билэк+ъязяк" гэсэн холбоо үгийн нийлэмжээс үүссэн бөгөөд "билек" (запьястья-бугуй) + ъязяк (кольцо-цагираг) гэж салах бөгөөд бугуйвчийг эртний түрэг хэлэнд bildzyk, татар башкир хэлэнд белээзк, узбек хэлэнд билагузик, уйгур хэлэнд билэйузузк гэх мэтээр нийтлэг нэрлэдэг (40:98) (41:106).

МНТ-ны "buka'u" буюу өвөг Алтай хэлний "buka'u" хэмээсэн үгтэй язгуур үндэс буюу цөм утга нь хүйн холбоотой хоёр сонирхолтой үг МНТ-нд гарч байна.

МНТ-ны 208-р зүйлд: "...bidan-aca kemleksen kem-ece oqor bugi duta'ulu'asu..." (1:173), 103-р зүйлд: "bьтн bey'e'en buru'udun bugiya moritu buqu-yin horim horimla...u..." (1:40) хэмээснийг орчуулагч, хөрвүүлэгч, судлаач нар янз бүрээр ухааран тайлсан байна. МНТ-ны "oqor bugi" гэсэн үгийг Е.Хэниш, С.Козин, Ф.В.Кливез, Онон Өргөнгөө зэрэг эрдэмтэд "уяа дээс", академич Ц.Дамдинсүрэн "шидмэс", академич Д.Цэрэнсодном "охор дээс", Ихмянгадай Иринчин, Тайчуудай Мансан, Ш.Гаадамба нар "буги" гэж орчуулж, хөрвүүлжээ. Элдэндэй, Ардаажав нар "oqor bugi" гэж хөрвүүлээд, хорчины аман ярианд дээс татлагыг "bu" гэж хэлдгийг дурджээ (9:963). МНТ-ны хажуугийн хятад хадмалд "дээс, уяа" гэж орчуулсан нь тун оновчтой болохыг түрэг, манж-түнгүүс, монгол хэл, аялгууны баримт нуталж байна. (Уг үгийн язгуур бүтээврийн тухай өмнө "buka'u" гэдэг үгийг тайлбарласан жишээ баримтаас тодотгон харж, харьцуулан үзнэ үү Ш.Ч).

МНТ-ны 103-р зүйлд гарч буй "bugiya moritu" гэсэн холбоо үгийг судлаачид "болхи бохио морь", "бүтэн (дан) морьт [болж]", "буухиа морь", "бухиа морь" гэх мэтээр орчуулж, хөрвүүлжээ. Хятад хадмалд "bugiya" гэдгийг "жолоо чөдөртэй" хэмээсэн ажээ.

Бидний эшлэсэн хэсгийг академич Ц.Дамдинсүрэн

"...Бүтэн биеэ

Бүгэн нуугдаж

Бүдэг замыг

Мөрдөн дагаж

Бугын мөрийг

Мөшгин хөөж..." (4:57) гэж орчин цагийн монгол хэлэнд хөрвүүлснээс ажиглахад, МНТ-ны "bugiya moritu" гэснийг "бүгт, бүдэг мөр" гэж ташаа ухаарсан бололтой. Энэ нь XVII зууны түүхч Лувсанданзаны ташаарсныг дагасан хэрэг юм. Лувсанданзаны "Алтан товч"-д "bьтн bey-e buru'ud-un bьkey-e mцr ть bu'и-yin orum orumla'u..." (46:25) гэж бичсэн байдаг. Энэ нь XVII зуунд Лувсанданзаны ашигласан уйгуржин монгол бичгээр буй эх нь бүдэг балархай байсан байж болохоос гадна "bugiya" гэдэг үг нэгэнт хуучирч, утга нь тодорхойгүй болчихсон байсныг гэрчилж байна.

Элдэндэй, Ардаажав нар "bugiya moritu" гэсэн холбоо үгийг тайлбарлахдаа, "Дагуур хэлэнд "bokigu" хэмээх нь хүлэх, аргамжлах, уях хэмээх буюу. Бугиа-гийн "шилжсэн утга" нь цулбуур чөдөр буюу" (9:243) гэсэн нь өмнө дурдан гаргасан жишээ баримтыг бас нэг хэлний нуталгаагаар баяжуулжээ. "bugiya" гэдэг үгийн бүтэц нь алтай язгуурын хэл, аялгуунуудад нийтэм тохиолдох "хүлэх, уях, боох, баглах" гэсэн утгатай үйл үгийн язгуур бүтээврийн "bug(i)" гэсэн нэг хувилбарт, нэрээс үйл үг үүсгэх "-ya (ye) [-γ-a (ge)]" дагаврыг залгаж бүтсэн ажээ. Монгол хэлний жишээгээр адилтгавал:

tusi+y-a→tusi-y-a (тушаа)

uya+γ-a→uya-y-a (уяа)

arγamji+y-a→arγamji-y-a (аргамжаа)

baγla+γ-a baγla-y-a (баглаа) гэх мэт.

МНТ-ны 103-р зүйлд гарч буй "...бүтэн биеэ буруудан, бугиа морьт, бугын ором оромлож..." хэмээснийг мөн хойно нь утга давтан өгүүлэхдээ "...ганцхан амиа хайрлан, ганц морьт, хандгайн ором оромлож..." гэсэн байдаг. Тухайн хэсгийн өгүүлэмжээс үзэхэд, Гурван мэргидэд нэхэгдэн хөөгдөж, Бурханы халдуны ой шугуйд зугатан буруулж орсон Тэмүжинд уяаны ганц морь л байсан нь нүдэнд харагдах мэт ажээ. "bugiya moritu", "qarqa moritu" гэсэн холбоо үгсийн "-tu (-ть)" дагаврын үг бүтээх утгыг бас бодолцох ёстой. Уг дагаврыг нэрийн язгуурт залгаж, тухайн зүйлийн буй бүхийг заасан нэр үг бүтээдэг бөгөөд жишээ нь давст (dabusutu) гэвэл давс бүхий газар гэсэн утгатай билээ. "bugiya moritu" гэдэг нь "уяа морь бүхий" хэмээсэн утгатай буюу.

МНТ-нд тохиолдох "buka'u", "bugi", "bugiya" гэсэн гурван үгийн язгуур бүтээвэр гарал нэг болох нь өмнө өгүүлсэн баримт сэлтийг нааш цааш харгуулан харьцуулж үзвээс лав лавдуун болох буй.

НОМ ЗҮЙ

1. Rachewiltz Igor de (1972), *Index to the secret history of the mongols*, Bloomington.
2. Хандсүрэн Ц (1997), *Цэнд гүн ба Монголын нууц товчоо*, Улаанбаатар.
3. Цэрэнсодном Д (2000), *Монголын нууц товчоо*, Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, Улаанбаатар.
4. Дамдинсүрэн Ц (1990), *Монголын нууц товчоо*, Дөрөв дэх хэвлэл, Улаанбаатар.
5. Mansang (1985), *Sin-e-ber orǎjulju tayilburilaṣan mongṣol-un niṣca tobḍyan*, Kцkeqota, 1985.
6. Bayar (1980), *Mongṣol-un niṣca tobḍyan*, I debter, Kцkeqota.
7. Yekemingyadai Irinčin (1987), *Mongṣol-un niṣca tobḍyan*, Kцkeqota.
8. Гаадамба Ш (1990), *Монголын нууц товчоо*, Улаанбаатар.
9. Eldendei, Ardaṣab (1986), *Mongṣol-un niṣca tobḍyan-u seyiregдыl tayilburi*, Kцkeqota.
10. Pelliot P (1949), *Histoire secrète des Mongols*, Paris.
11. Erich Haenisch (1962), *Wörterbuch zu manghol un niuca tobca'an* (уъан ch'ao pi-shi), Wiesbaden.
12. Cleaves F.W (1982), *The Secret History of the Mongols*, Translated and edited by F.W.Cleaves, London.
13. Urgunge Onon (1993), *Chinggis khan, The golden history of the Mongols*, Translated and with an introduction by Urgunge Onon, London.
14. Козин С.А (1990), *Сокровенное сказание монголов*, Перевод С.А.Козина, Улан-Үдэ.
15. Ahmet Temir (1995), *Moğolların giri tarihi*, (Yazılışı: 1240), Ankara.
16. Stanislaw Kaluzynski (1970), *Tajna historia mongolów*, Warszawa.
17. Ozawa (1985), *Монголын нууц товчооны бүрэн тайлбар*, 2-р боть, (япон хэлээр), Токио.
18. *Kitad mongṣol tol* (1996), Kцkeqota.
19. *Древнетюркский словарь* (1969), Ленинград.
20. Малов С.Е (1951), *Памятники древнетюркской письменности*, Москва-Ленинград.
21. Martti Räsänen (1969), *Versuch eines etymologischen wörterbuchs der Turksprachen*, Helsinki.
22. *Русско-киргизский словарь* (1957), (Под редакцией К.К.Юдахина), Москва.
23. *Русско-каракалпакский словарь* (1967), (Под редакцией Н.А.Баскакова), Москва.
24. Магазаник Д.А (1945), *Турецко-русский словарь*, Москва.
25. Базылхан Б (1984), *Монгол-казак толь*, Улаанбаатар-Өлгий.
26. *Русско-тувинский словарь* (1953) Москва.
27. *Русско-таджикский словарь* (1985) (Под редакцией М.С.Асимова), Москва.
28. *Уйгурско-русский словарь* (1968) (Под редакцией Э.Н.Наджап), Москва.
29. *Русско-бурят-монгольской словарь* (1954) (Под редакцией Ц.Б.Цыдендамбаева), Москва.
30. *Русско-калмыцкий словарь* (1964) Под редакцией И.К.Илишкина, Москва.
31. Hans-Peter Vietze, Gendeng Lubsang (1992), *Altan tobḍ*, (Eine mongolische Chronik des XVII. Jahrhunderts von Blo bzang bstan 'jin), Text and Index, Tokyo.
32. *Qad-un yndьsьn quriyangṣui altan tobḍ* (1989), Bulay qaryuṣulju tayilburilaba, Kцkeqota.
34. Sayan sečen (1984), *Erdeni-yin tobḍ*, Kцkeqota.
35. *Qorin nigetъ tayilburi tol*" (1979), Kцkeqota.

36. Цолоо Ж (1995), *Монгол хэлний нутгийн аялгууны гоёл чимгийн нэр томъёо*, Mongolica (An international annual of mongol studies), vol. 6(27), Улаанбаатар, 89-102.
37. Цэвэл Я (1966), *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар.
38. Цолоо Ж (1988), *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг*, II дэвтэр, Ойрд аялгуу, Улаанбаатар.
39. Лувсанжав Ч, Шархүү Г (1968), *Манж монгол толь*, Улаанбаатар.
40. Poppe N (1960), *Vergleichende grammatik der altaischen sprachen*, Otto Harrassowitz Wiesbaden.
41. Колесникова В.Д (1972), *Названия частей тела человека в алтайских языках*, (Очерки сравнительной лексикологии алтайских языков), Ленинград, 71-104.
42. Щербак А.М (1997), *Ранние тюркско-монгольские языковые связи*, (VIII-XIV вв), Санкт-Петербург.
43. *Nutuγ-un ayalγun-u ьges-ьн quriyangγui*" (1992), Norjin, Čoyidandar nar naiyraγulba, Кцке qota.
44. Сеҗенсöγtu (1988), *Mongγol ьges-ьн ijaγur-un toli*, Кцке qota.
45. Тодоева Б.Х (1981), *Язык монголов внутренней монголии* (материалы и словарь), Москва.
46. Ууганбаяр М (1996), *МНТ-ны зарим үг хэллэгийн тайлбар*, Улаанбаатар.
47. *Алтан товч* (1990), (Лувсанданзаны "Алтан товч"-ийн эх бичгийн хуулбар), Улаанбаатар.

SUMMARY

This paper stresses the importance of studying the transformation and inheritance of the words an compound words in modern Mongolian from the vocabulary of *The Secret History of the Mongols*, by thoroughly analysing the evolution of word *buha'u* which occurs repeatedly in five different chapters of the chronicle.

The conclusion is that the name of a punishment instrument worn on criminals' neck and wrists was gradually transferred into a name of an ornament an further it was changed into the name of a body part, the lower end of the forearm in some Mongolian dialects such as Khalkha. In some Oirat dialects, for instance, Dürbed, Zakhchin, Torgut, Цлүт, Uriangkhai, Bait and Khoton, both wrist and bracelet share the same name *buyuu*. The paper also tackles the problem of the common origin of words *buka'u*, *bugi*, *bugiya* from *The Secret History of Mongols*.